

Хүүхдээ сургуульд элсэн суралцахад хэрхэн бэлтгэх вэ

Бэлтгэл анги болон өдөр өнжүүлэхэд явж буй таны хүүхэд 4 настны эрүүл мэнд, хөгжлийн үзлэгт **үнэ төлбөргүй** хамрагдах боломжтой.



Гэр бүлд зориулсан мэдээллийн хуудас



4 настны эрүүл мэнд, өсөлт хөгжлийн үзлэг нь:

- хүүхдийн өсөлт хөгжил насандаа тохирч байгаа эсэхийг шалгахад тусална
- сургуульд орохоос өмнө тусламж дэмжлэг үзүүлэх шаардлагатай эсэхийг илрүүлэхэд тусална
- мөн харьяа өрхийн эмнэлэг, эмчдээ хандан уг үзлэгт хамрагдах боломжтой.

Үзлэгийн үеэр

Эрүүл мэндийн ажилтнууд таны хүүхдийн дараах зүйлсийг шалгана:

- Өндөр, жин, амны хөндийн эрүүл мэнд
- Сонсох, ярих чадвар
- Нийгмийн ур чадвар, зан төлөв
- Биеийн ерөнхий ба нарийн хөдөлгөөний ур чадвар
- Сэтгэн бодох чадвар, асуудал шийдвэрлэх чадвар.

Ямар нэгэн дархлаажуулалт үзлэгийн үеэр хийгдэхгүй.

Үзлэгийн өдөр таны хүүхдийн ангийн багш хамт байлцах болно. Та бас уг үзлэгт оролцмоор байгаа бол биднээс асуугаарай.

Үзлэгийн дараа

Үзлэгийн дараа та хүүхэддээ хэрхэн тусламж дэмжлэг үзүүлбэл зохих талаар хураангуй мэдээллийг авах болно. Хэрэв таны хүүхдэд нэмэлт дэмжлэг хэрэгтэй байгаа бол эрүүл мэндийн ажилтнууд туслах болно.

Та хүүхдийнхээ багштай хүүхдэд сургуулийн зүгээс ямар дэмжлэг туслалцаа үзүүлж болох талаар ярилцаж болно. Хэрэв хүсвэл уг үзлэгийн тайланг тэдэнтэй хуваалцаж болно.



Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл [health.nsw.gov.au/ECCEchecks](https://nsw.gov.au/ECCEchecks) руу орж **QR кодыг уншуулна уу**

Байнга асуудаг асуултууд

Асуулт: Яагаад бэлтгэл анги болон өдөр өнжүүлэхэд энэ үзлэгийг хийдэг вэ?

NSW мужийн олон хүүхдүүд 4 настны үзлэгтээ хамрагдаж чаддаггүй. Үзлэгт орох боломжийг хялбаршуулснаар илүү олон хүүхэд сургуульд орохоосоо өмнө хшаардлагатай тусламж дэмжлэг авах боломжтой болдог.

Асуулт: Би хүүхдээ энэ үнэ төлбөргүй үзлэгт хэрхэн бүртгүүлэх вэ?

Таны хүүхдийн цэцэрлэг эсвэл өдөр өнжүүлэхээс үзлэг хэзээ болохыг танд хэлэх болно. Үзлэгийн өдөр болохоос өмнө зөвшөөрлийн маягтад гарын үсэг зуран буцааж өгнө үү.

Асуулт: Хэрэв хүүхэд маань тухайн өдөр үзлэгт орж чадахгүй бол яах вэ?

Та хүүхэдтэйгээ эмч дээрээ эсвэл харьяа өрхийн эмнэлэг дээр очиж 4 настны үзлэгт нь хамруулж болно.

Асуулт. Хэрэв хүүхэд маань 4 настны үзлэгт хамрагдсан байгаа бол яах вэ?

Хэрэв таны хүүхэд 4 настны үзлэгт аль хэдийн орсон бол дахин үзлэгт орох шаардлагагүй.